



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/163


Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 18/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд ашиглаж байгаа Биохимийн аппаратны урвалж бодис, оношлуур авах зардалд 15,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.2-т тусгагдсан Эрүүл мэндийн салбарын “Эрүүл иргэн” хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батнасан), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн) нарт зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 2686

Zah A/163.Kh

Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 20-ны өдрийн
А/163 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Төсөв	Хугацаа	Нийт үнэ
1	Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төв	6 сарын хэрэглээ	3,000,000
2	Буянт өрхийн эрүүл мэндийн төв	6 сарын хэрэглээ	3,000,000
3	Бугат өрхийн эрүүл мэндийн төв	6 сарын хэрэглээ	3,000,000
4	Жаргалан өрхийн эрүүл мэндийн төв	6 сарын хэрэглээ	3,000,000
5	Рашаант өрхийн эрүүл мэндийн төв	6 сарын хэрэглээ	3,000,000
НИЙТ ДҮН			15,000,000

-оОо-